



БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

НИЙЦЛИЙН АУДИТЫН ТАЙЛАН

АУДИТЫН НЭР: НАМ, ЭВСЭЛ, НЭР ДЭВШИГЧИЙН СОНГУУЛИЙН  
ЗАРДЛЫН САНХҮҮЖИЛТ, ТҮҮНИЙ ГҮЙЦЭТГЭЛД АУДИТ ХИЙЖ  
ДҮГНЭЛТ ГАРГАН НИЙТЭД МЭДЭЭЛЭХ

АУДИТЫН КОД: ГНАГ-2024/12-ШТА-НА-БНА

Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын дарга,  
Тэргүүлэх аудитор **Б.Мөнхбат**

Утас: 70442584 цахим хуудас: [munkhbatb@audit.gov.mn](mailto:munkhbatb@audit.gov.mn)

Аудитын менежер **М.Алтантуяа**

Утас: 70442424 цахим хуудас: [altantuyam@audit.gov.mn](mailto:altantuyam@audit.gov.mn)

Ахлах аудитор **Б.Азбаяр**

Утас: 99061429 цахим хуудас: [azbayarb@audit.gov.mn](mailto:azbayarb@audit.gov.mn)

**АГУУЛГА**

Товчилсон үгийн жагсаалт ..... 3

Аудитын зорилт, хамарсан хүрээ, стандарт, арга зүйн талаарх мэдэгдэл ..... 4

**БҮЛЭГ 1. АЙМАГ, СУМЫН ИТХ-ЫН 2024 ОНЫ ЭЭЛЖИТ СОНГУУЛЬД НЭР ДЭВШИГЧДЭД МӨНГӨН ХАНДИВ ӨГСӨН ИРГЭД ХУУЛЬД ЗААСНЫ ДАГУУ ОРЛОГО ТӨВЛӨРҮҮЛЭХДЭЭ ИРГЭНИЙ БҮРТГЭЛИЙН ДУГААР, ОРЛОГЫН ЭХ ҮҮСВЭРИЙГ БҮРЭН БИЧЭЭГҮЙ БАЙНА. .... 6**

ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГАД ДАНСНЫ МЭДЭЭЛЛИЙГ БҮРЭН ИРҮҮЛЭЭГҮЙ БАЙНА. .... 6

БАЯНХОНГОР АЙМАГТ САЛБАРТАЙ АРИЛЖААНЫ 2 БАНК НЭР ДЭВШИГЧИЙН ДАНСНЫ МЭДЭЭЛЛИЙГ ХУУЛЬД ЗААСНЫ ДАГУУ ИРҮҮЛЭЭГҮЙ БАЙНА. .... 6

**БҮЛЭГ 2. СОНГУУЛИЙН ЗАРДЛЫГ ДАНСЫГ 36 НЭР ДЭВШИГЧ ХААГААГҮЙ ҮЛДЭГДЭЛТЭЙ БАЙНА. 7**

ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГАД ТАЙЛАН ИРҮҮЛСЭН АЙМГИЙН МАН, АН, ХҮН НАМ БОЛОН 613 НЭР ДЭВШИГЧ СОНГУУЛИЙН ЗАРДЛЫН ТАЙЛАНД ХУВИЙН АУДИТЫН КОМПАНИАР ДҮГНЭЛТ ГАРГУУЛСАН БАЙНА. .... 7

НЭР ДЭВШИГЧИД СОНГУУЛИЙН ЗАРДАЛД 168,023.9 МЯНГАН ТӨГРӨГИЙГ ЗАРЦУУЛСАН БАЙНА. .... 7

СОНГУУЛИЙН ЗАРДЛЫН ТҮР ДАНСЫГ 36 НЭР ДЭВШИГЧ ХААГААГҮЙ, ҮЛДЭГДЭЛТЭЙ БАЙНА. .... 8

**ДҮГНЭЛТ: 8**

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт
УИХ	Улсын Их Хурал
ҮАГ	Үндэсний аудитын газар
ИТХ	Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал
УБЕГ	Улсын бүртгэлийн Ерөнхий газар
СЕХ	Сонгуулийн Ерөнхий хороо
ЗДТГ	Засаг даргын Тамгын газар
ХХК	Хязгаарлагдмал хариуцлагатай компани

<b>Аудит хийсэн үндэслэл, бүрэн эрх</b>	<b>Аудитын зорилт, хамарсан хүрээ, стандарт, арга зүйн талаарх мэдэгдэл</b> <p>Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн төлөөлөгчдийн хурлын сонгуулийн тухай хуулийн 49 дүгээр зүйлийн 49.1-т заасан үндэслэлээр Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.3 дахь заалт, 15 дугаар зүйлийн 15.1 дэх заалтыг үндэслэн УИХ-ын Төсвийн байнгын хорооны “Аудитын сэдэв батлах тухай” 2023 оны 08 дугаар тогтоол, Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын 2024 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөг үндэслэн аудитыг гүйцэтгэв. Аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 57 дугаар зүйлийн 57.1 дэх “Төрийн аудитын орон нутаг дахь салбар байгууллага зардлын тайланг хүлээн авсан өдрөөс хойш 60 хоногийн дотор хянаж, дүнг нийтэд мэдээлэх бөгөөд нэг сая ба түүнээс дээш төгрөгийн хандив өгсөн иргэн, хоёр сая ба түүнээс дээш төгрөгийн хандив өгсөн хуулийн этгээдийг нийтэд мэдээлнэ” гэж заасныг үндэслэн нам, нэр дэвшигчийн сонгуулийн зардлын тайланг хянаж баталгаажуулав.</p>
<b>Аудитын зорилт</b>	Аймаг, сумын 2024 оны ээлжит сонгуульд оролцсон нам болон нэр дэвшигчийн төвлөрүүлсэн орлого, иргэн, хуулийн этгээдээс өгсөн хандив, сонгуулийн зардлын тайланг хянаж, дүнг холбогдох байгууллага, албан тушаалтанд танилцуулж, нийтэд мэдээлэхэд аудитын зорилт чиглэгдэв. <p>Дээрх зорилтын хүрээнд дараах чиглэлийн дагуу аудитыг гүйцэтгэв.Үүнд:</p> <ol style="list-style-type: none"><li>1. Нам, эвсэл болон бие даан нэр дэвшигч нар хуульд заасан орлогыг сонгуулийн зардлын дансанд төвлөрүүлсэн эсэх?</li><li>2. Нам, эвсэл болон бие даан нэр дэвшигч нар сонгуулийн зардлын данснаас хуулийн дагуу зарлага гаргасан эсэх?</li></ol>
<b>Аудитын хамарсан хүрээ</b>	Аймаг, сумын ИТХ-ын 2024 оны ээлжит сонгуульд оролцсон нам, эвслээс болон бие дааж нэр дэвшигчдийн аудитын дүгнэлт, аудитын дэлгэрэнгүй тайлан, аудит хийгдсэн сонгуулийн зардлын тайлангийн маягтууд, харилцагч банкны дансны хуулга бусад шаардлагатай баримтуудыг хамруулж, аудитыг гүйцэтгэв.
<b>Аудитын арга зүй</b>	Аудитын ажлыг гүйцэтгэхэд Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, Тэргүүлэх аудиторын 2024.10.10-ны өдрийн А/29 дүгээр тушаалаар баталсан “Аймаг, сумын иргэдийн төлөөлөгчдийн хурлын сонгуульд оролцож байгаа нам, эвсэл, нэр дэвшигч сонгуулийн зардлын тайлан гаргах, зардлын тайланд аудит хийх, хянах, дүнг нийтэд мэдээлэх, танилцуулах журам”-ыг үндэслэн нэр дэвшигчдийн өөрийн хөрөнгө, нам, эвслээс оруулсан хөрөнгө, иргэн, хуулийн этгээдээс авсан хандив түүний зарцуулалтын тайланг шалгаж, аудит хийсэн хуулийн этгээд, нам, эвсэл, нэр дэвшигчдээс лавлагаа, тодруулга авч, бусад шаардлагатай баримт материалд тулгуурлан аудитын горимын дагуу нотлох зүйл цуглуулж тайланг, хавсралт маягтуудыг бэлтгэв.
<b>Аудитын шалгуур үзүүлэлт</b>	Аудитад дараах хууль, эрх зүйн актыг шалгуур үзүүлэлт болгон ашиглав. <ul style="list-style-type: none"><li>• Төрийн аудитын тухай хууль;</li><li>• Сонгуулийн төв байгууллагын тухай хууль;</li><li>• Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хууль</li><li>• Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль</li></ul>

<p><b>Аудитын багийн бүрэлдэхүүн, хугацаа</b></p>	<ul style="list-style-type: none"><li>• Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын дарга бөгөөд Тэргүүлэх аудиторын 2024.10.10-ны өдрийн А/29 дүгээр тушаалаар баталсан “Аймаг, сумын иргэдийн төлөөлөгчдийн хурлын сонгуульд оролцож байгаа нам, эвсэл, нэр дэвшигч сонгуулийн зардлын тайлан гаргах, зардлын тайланд аудит хийх, хянах, дүнг нийтэд мэдээлэх, танилцуулах журам”</li><li>• Бусад холбогдох хууль, дүрэм, журам.</li></ul> <p>Аудитыг Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын Дарга, тэргүүлэх аудитор Б.Мөнхбат удирдаж, аудитын менежер М.Алтантуяа үе шатны чанарын хяналтыг хэрэгжүүлж, ахлах аудитор Б.Азбаяр, аудитор Д.Цэдэвцэвээн, Д.Даваадорж, А.Адилзаяа, Г.Энхзул нар хамтран гүйцэтгэв.</p> <p>Аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу аудитыг 2024.11.25-ний өдөр эхлүүлж, Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, Тэргүүлэх аудиторын 2025 оны А/01 дугаар тушаалаар баталгаажуулж, Төрийн аудитын байгууллагын (<a href="http://www.audit.mn">www.audit.mn</a>) цахим хуудаст 2025.01.09-ний дотор байршуулж, нийтэд мэдээлнэ.</p>
---	--

## НИЙЦЛИЙН АУДИТЫН ДҮН

**БҮЛЭГ 1. АЙМАГ, СУМЫН ИТХ-ЫН 2024 ОНЫ ЭЭЛЖИТ СОНГУУЛЬД НЭР ДЭВШИГЧДЭД МӨНГӨН ХАНДИВ ӨГСӨН ИРГЭД ХУУЛЬД ЗААСНЫ ДАГУУ ОРЛОГО ТӨВЛӨРҮҮЛЭХДЭЭ ИРГЭНИЙ БҮРТГЭЛИЙН ДУГААР, ОРЛОГЫН ЭХ ҮҮСВЭРИЙГ БҮРЭН БИЧЭЭГҮЙ БАЙНА.**

ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГАД ДАНСНЫ МЭДЭЭЛЛИЙГ БҮРЭН ИРҮҮЛЭЭГҮЙ БАЙНА.

1.1. Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 50 дугаар зүйлийн 50.1<sup>1</sup>, 50.2<sup>2</sup> дахь заалтын дагуу давхардсан тоогоор 925 нэр дэвшигч данс нээхээс 673 данс нээж 252 нэр дэвшигч сонгуулийн зардлын дансыг нээгээгүй байна.

1.2. Орон нутгийн сонгуульд нэр дэвшиж арилжааны банкинд хандивын данс нээсэн 687 нэр дэвшигчээс Баянхонгор аймгийн МАН 35, Баянхонгор сумын МАН 29, Өлзийт сумын МАН 21, Ардчилсан нам 475, Хүрээмарал сумын Ардчилсан нам 15, нийт 575 нэр дэвшигч дээрх хуулийн 50 дугаар зүйлийн 50.3<sup>3</sup> дахь заалтын дагуу данс нээсэн мэдээллээ ирүүлсэн байна.

**БАЯНХОНГОР АЙМАГТ САЛБАРТАЙ АРИЛЖААНЫ 2 БАНК НЭР ДЭВШИГЧИЙН ДАНСНЫ МЭДЭЭЛЛИЙГ ХУУЛЬД ЗААСНЫ ДАГУУ ИРҮҮЛЭЭГҮЙ БАЙНА.**

1.3. Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн төлөөлөгчдийн хурлын сонгуулийн тухай хуулийн 56 дугаар зүйлийн 56.5<sup>4</sup>-т заасныг Баянхонгор аймагт үйл ажиллагаа явуулж байгаа Хаан банк, Төрийн банкны салбарууд хэрэгжүүлж ажилласан байна. Харин Хас банк 11, Худалдаа хөгжлийн банк 3 нэр дэвшигчийн мэдээллийг ирүүлээгүй байна.

**ИРГЭД НЭР ДЭВШИГЧИЙН ДАНСАНД МӨНГӨН ХАНДИВ ӨГӨХДӨӨ ХУУЛЬД ЗААСАН МЭДЭЭЛЛИЙГ БАНКНЫ ГҮЙЛГЭЭНИЙ УТГАД БИЧЭЭГҮЙ НИЙТЛЭГ ЗӨРЧИЛТЭЙ БАЙНА.**

1.4. Аймаг, сумын ИТХ-ын 2024 оны ээлжит сонгуульд нэр дэвшсэн Монгол ардын намд 6 иргэнээс 10,001.0 мянга, Ардчилсан намд нэг иргэнээс 1,000.0 мянган төгрөгийн мөнгөн хандив өгсөн байна.

1.5. Аймаг, сумын ИТХ-д нэр дэвшсэн 925 нэр дэвшигчээс 613 иргэн сонгуулийн зардлын тайланг ирүүлж, 312 нэр дэвшигч тайлан ирүүлээгүй байна.

1.6. Сонгуулийн зардлын тайлан ирүүлсэн 616 нэр дэвшигчдийн дансанд 7,900.0 мянган төгрөгийн нэр дэвшигчийн өөрийн хөрөнгө, 11 хуулийн этгээдээс өгсөн 50,215.9 мянга, 462 иргэнээс өгсөн 110,861.0 мянга, нийт 168,976.9 мянган төгрөгийн мөнгөн хандив төвлөрсөн байна.

<sup>1</sup> Нам, эвсэл тухайн аймаг, нийслэл, сум, дүүрэгтээ сонгуулийн зардлын төгрөгийн нэг данстай байна.

<sup>2</sup> Нам, эвсэл болон нэр дэвшигчийг сонгуульд оролцуулахаар бүртгэх тухай шийдвэр гарснаас хойш энэ хууль болон банкны хууль тогтоомжид нийцүүлэн сонгуулийн зардлын дансыг нээлгэнэ.

<sup>3</sup> Нам, эвсэл болон нэр дэвшигч нь сонгуулийн зардлын дансны дугаар, банкны нэрийг санал авах өдрөөс 20-оос доошгүй хоногийн өмнө төрийн аудитын орон нутаг дахь салбар байгууллагад мэдэгдэж, бүртгүүлэх үүрэгтэй.

<sup>4</sup> Сонгуулийн зардлын данс байршуулсан банкны захирал, эсхүл салбарын эрхлэгч уг дансны бүх гүйлгээний хуульыг гаргаж, санал авах өдрөөс хойш 30 хоногийн дотор төрийн аудитын орон нутаг дахь салбар байгууллагад хүргүүлнэ.

1.7. Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн төлөөлөгчдийн хурлын сонгуулийн тухай хуулийн 53 дугаар зүйлийн 53.4<sup>5</sup>-т заасан шаардлагыг хангаагүй 49,802.1 мянган төгрөгийн хандивыг 26 нэр дэвшигч хандив өгсөн этгээдэд буцаан шилжүүлээгүй байна.

1.8. Аймаг, сумын ИТХ-д оролцсон 37 нэр дэвшигч өөрийн харилцах дансанд төвлөрсөн орлогыг нэр хаяг тодорхой бус гэж үзэж, Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн төлөөлөгчдийн хурлын сонгуулийн тухай хуулийн дээрх заалтын дагуу 94 гүйлгээгээр 15,482.8 мянган төгрөгийг хандив өгсөн хүний дансанд буцаан шилжүүлсэн байна.

## БҮЛЭГ 2. СОНГУУЛИЙН ЗАРДЛЫГ ДАНСЫГ 36 НЭР ДЭВШИГЧ ХААГААГҮЙ ҮЛДЭГДЭЛТЭЙ БАЙНА.

ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГАД ТАЙЛАН ИРҮҮЛСЭН АЙМГИЙН МАН, АН, ХҮН НАМ БОЛОН 613 НЭР ДЭВШИГЧ СОНГУУЛИЙН ЗАРДЛЫН ТАЙЛАНД ХУВИЙН АУДИТЫН КОМПАНИАР ДҮГНЭЛТ ГАРГУУЛСАН БАЙНА.

1.9. Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн төлөөлөгчдийн хурлын сонгуулийн тухай хуулийн 56 дугаар зүйлийн 56.3<sup>6</sup> дахь заалтыг хэрэгжүүлж МАН, АН, ХҮН нам зардлын тайланг ирүүлсэн байна.

1.10. Тайлан ирүүлсэн 613 нэр дэвшигчээс 306 нэр дэвшигчийн дансанд орлого зарлагын гүйлгээ гараагүй байна.

НЭР ДЭВШИГЧИД СОНГУУЛИЙН ЗАРДАЛД 168,023.9 МЯНГАН ТӨГРӨГИЙГ ЗАРЦУУЛСАН БАЙНА.

1.11. Нэр дэвшигчид сонгуулийн үйл ажиллагааны зардлыг доорх байдлаар зарцуулсан байна.

Хүснэгт №1. Нэр дэвшигч нарын сонгуулийн зардал

Зардлын ангилал	Мөнгөн дүн /мянган төгрөг/
Сонгуулийн сурталчилгааны материал хэвлүүлэх, сонгогчдод тараах зардал	63,954.3
Нийтийн эзэмшлийн гудамж, талбайд сонгуулийн сурталчилгааны зурагт самбар байршуулах зардал	1,395.1
Намын далбааг гудамж, талбайд байршуулах, таних тэмдэг, уриа ашиглах зардал	566.6
Сонгогчидтой уулзалт, хурал, цуглаан хийх зардал	33,965.2
Сонгуулийн үйл ажиллагаа /түрээс, урамшуулал, тээвэр, томилолт, сурталчилгаа/	50,070.8
Сонгуулийн сурталчилгаанд радио, телевиз ашиглах зардал	1,229.4
Цахим орчин ашиглах зардал	1,810.9
Сонин сэтгүүлд материал хэвлүүлэх	1,940.5
Бусад зардал	13,090.9
Нийт дүн	168,023.9

Эх үүсвэр: Аймаг, сумын ИТХ-ын сонгуульд оролцсон нэр дэвшигч нарын аудитлагдсан тайлан

Дээрх зардлыг хүн тус бүрээр авч үзэхэд Төрийн аудитын байгууллагаас тогтоосон зардлын дээд хэмжээнээс хэтрээгүй байна.

1.12. Нэр дэвшигч нараас ирүүлсэн тайланд өр төлбөр тайлагнаагүй байна.

<sup>5</sup> Хандив өгч байгаа иргэн, хуулийн этгээд нь нэр, иргэний бүртгэлийн дугаар болон хандивын эх үүсвэрийн талаарх мэдээллээ банкны гүйлгээний баримтад тусгах бөгөөд энэ шаардлагыг хангаагүй хандивыг хандив хүлээн авагч буцаан шилжүүлнэ.

<sup>6</sup> Нам, эвсэл нь санал авах өдрөөс хойш 45 хоногт, нэр дэвшигч санал авах өдрөөс хойш 30 хоногт багтаан зардлын тайландаа хувийн аудитын хуулийн этгээдээр дүгнэлт гаргуулан, төрийн аудитын орон нутаг дахь салбар байгууллагад хүргүүлнэ.

**СОНГУУЛИЙН ЗАРДЛЫН ТҮР ДАНСЫГ 36 НЭР ДЭВШИГЧ ХААГААГҮЙ, ҮЛДЭГДЭЛТЭЙ БАЙНА.**

Сонгуулийн үйл ажиллагаанд ашиглагдахаар арилжааны банканд нээсэн дансыг 36 нэр дэвшигч хаагаагүй, 953,0 мянган төгрөгийн үлдэгдэлтэй байгаа нь Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн төлөөлөгчдийн хурлын сонгуулийн тухай хуулийн 51 дүгээр зүйлийн 51.17 дэх заалтыг зөрчсөн тул жагсаалтыг Баянхонгор аймаг дахь Монгол банкинд хүргүүлэв.

**ДҮГНЭЛТ:**

Аудитын дүнд үндэслэн дараах дүгнэлтийг гаргаж байна.

1. Аймаг, сумын ИТХ-ын 2024 оны ээлжит сонгуульд оролцсон нам, нэр дэвшигч нар сонгуулийн зардлын данс нээх, дансны мэдээллийг болон аудитын хуулийн этгээдээр гаргуулсан аудитын дүгнэлтийг Төрийн аудитын байгууллагад ирүүлэх, хандивын орлогыг хүлээн авах, данс хаах тухай ойлголт дутмаг байгаагаас хуулийн хэрэгжилт хангалтгүй байна.
2. Аймаг, сумын Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын 2024 оны ээлжит сонгуульд оролцсон намууд 6 иргэнээс нэг сая төгрөгөөс дээш 11,000.0 мянган төгрөгийн хандив, нэр дэвшигчид 17 иргэнээс нэг сая ба түүнээс дээш төгрөгийн 31,050.0 мянган төгрөг, 7 хуулийн этгээдээс хоёр сая ба түүнээс дээш төгрөгийн 48,388.8 мянган төгрөгийн хандив авсныг Аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 57 дугаар зүйлийн 57.1-т заасны дагуу нийтэд мэдээлсэн.
3. Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн төлөөлөгчдийн хурлын сонгуулийн тухай хуулийн 56 дугаар зүйлийн 56.3 дахь заалтыг зөрчиж, 312 нэр дэвшигч зардлын тайлан ирүүлээгүй байна.
4. Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн төлөөлөгчдийн хурлын сонгуулийн тухай хуулийн 53 дугаар зүйлийн 53.4-т заасан шаардлагыг хангаагүй 49,802.1 мянган төгрөгийн хандивыг 26 нэр дэвшигч хандив өгсөн этгээдэд буцаан шилжүүлээгүй байна.

-оОо-

<sup>7</sup> Нам, эвсэл болон нэр дэвшигчийг сонгуульд оролцуулахаар бүртгэсэн өдрөөс эхэлж, сонгуулийн зардлын тайлан гаргах өдрийг дуусах хүртэл хугацаанд энэ хуулийн 38.2-т заасан арга хэлбэрээр сонгуулийн сурталчилгаа явуулах зориулалтаар сонгуулийн зардлын данснаас дансанд шилжүүлэх хэлбэрээр зарлага гаргаж болно.

Нам эвсэлд хандив өгсөн иргэн хуулийн этгээдийн жагсаалт

№	Нам, эвслийн нэр	Хандив өгсөн иргэн болон хуулийн этгээдийн нэр	Мөнгөн хандивын дүн	
			Иргэн / Нэг сая төгрөгөөс дээш/	Хуулийн этгээд / Хоёр сая төгрөгөөс дээш/
1	Монгол ардын нам	Ж.Хашбат	2,000,000	
2	Монгол ардын нам	Х.Азжаргал	2,000,000	
3	Монгол ардын нам	Э.Долгорсүрэн	2,000,000	
4	Монгол ардын нам	С.Тогоохүү	2,000,000	
5	Монгол ардын нам	С.Гантулга	2,000,000	
6	Ардчилсан нам	Ч.Гантулга	1,000,000	
Нийт дүн			11,000,000	-

Нэр дэвшигчдэд хандив өгсөн иргэн хуулийн этгээдийн жагсаалт

№	Нэр дэвшигч	Хандив өгсөн иргэн болон хуулийн этгээдийн нэр	Мөнгөн хандивын дүн	
			Иргэн / Нэг сая төгрөгөөс дээш/	Хуулийн этгээд / Хоёр сая төгрөгөөс дээш/
1	Б.Батбаяр	Н.Ууганбаяр	2,000,000	
2	Б.Батсуурь	Ш.Баянжаргал	2,000,000	
3	М.Мөнхбат	М.Алтанцэцэг	1,900,000	
4	М.Мөнхбат	Д.Балжмаа	1,900,000	
5	М.Мөнх-эрдэнэ	Бямбасайхан	1,000,000	
6	Б.Энхтүвшин	Х.Чинбаяр	2,000,000	
7	Ж.Дулмаа	Пүүлээ	5,000,000	
8	Д.Сайнжаргал	Хонгор Бээс транс		10,000,000
9	Т.Бат-очир	Энх мөнх транс ХХК		10,000,000
10	Т.Баярмагнай	LVH Agro LLC		10,000,000
11	Ж.Хүрэлбаатар	Зоригт болд ХХК		2,500,000
12	Ч.Өлзийжаргал	Чимэддаваа	2,000,000	
13	М.Баттөр	Г.Хүрэлбаатар	2,000,000	
14	М.Баттөр	О.Анхбаяр	1,000,000	
15	М.Баттөр	Х.Норов	1,000,000	
16	М.Цэвэлмаа	Ү.Гантиг	1,750,000	
17	Э.Сүхбаатар	Ү.Гантиг	1,750,000	
18	Ч.Батмөнх	Ү.Гантиг	1,750,000	
19	Х.Чимэдцэеэ	Б.Батдорж	1,000,000	
20	Н.Гансүх	А.Батмагнай	1,000,000	
21	М.Баттөр	Баянгол ресторт ХХК		5,000,000
22	М.Баттөр	Дижитал актив ХХК		8,888,888
23	П.Лхагвасүрэн	А.Энхзориг	2,000,000	
24	Д.Сайнбаяр	Хонгор Бээс транс		2,000,000
Нийт дүн			31,050,000	48,388,888